



Исаиа гэж хэн бэ?

Мормоны Номоос бид Исаиа гэдэг хүний үгийг уншдаг. Исаиа Хуучин Гэрээний бошиглогч байв. Тэр Есүс Христийг мэндлэхээс олон жилийн өмнө амьдарч байжээ.



Исаиа Есүс Христийн амьдралын талаар заасан. Тэрээр Есүс энэ дэлхийд амар амгаланг авчирна гэж хэлсэн. Есүс нас барж, амилж, бас дэлхийд хэзээ нэгэн өдөр эргэн ирэх тухай тэр заажээ.



Олон зуун жилийн дараа, Нифай Есүс Христийн тухай бидэнд заахын тулд Исаиагийн үгсийг Мормоны Номд бичжээ. Есүс нифайчууд дээр айлчлахдаа Исаиагийн үгийг хуваалцсан. Тэр биднийг тэдгээрийг судлахыг хүссэн. Исаиагийн үгийг судалснаар бид Аврагчийн хайрыг мэдэрч Түүнд илүү ойртож чадна. ●

Судрын сорил

2 Нифай 19:6-г уншина уу. Энэ шүлэгт Есүсийн хэдэн янзын нэр байна вэ?

Аврагчийн баптисмын үеэр Ариун Сүнс байсныг харуулж ямар амьтан үзэгдсэн бэ?
Сэжүүр: 2 Нифай 31:8

Хэнийг амилуулах вэ?
Сэжүүр: Алма 11:44

Би Мормоны Номыг уншиж чадна!

Уншсаныхаа дараа зургийн хэсгийг будаарай. Та нар *Ирээд, Намайг дага* дахь долоо хоног бүрийн эдгээр судрыг уншиж болно.

- 1 **дэх долоо хоног:** 2 Нифай 11:2
- 2 **дахь долоо хоног:** 2 Нифай 24:3
- 3 **дахь долоо хоног:** 2 Нифай 26:23–24
- 4 **дэх долоо хоног:** 2 Нифай 32:5
- 5 **дахь долоо хоног:** 2 Нифай 9:13



Есүс бол “Энх Амгалангийн Ханхүү” хэмээн Исаиа заасан (2 Нифай 19:6). Амар амгаланг мэдрэхэд чинь тусалдаг ямар нэг зүйлийн тухай зурж эсвэл зургийг нь аваарай. Зургаа *Найз* сэтгүүл рүү илгээгээрэй!
Зааврыг арын хавтаснаас үзнэ үү.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭН СИМОНСЭН

ХАРИУЛ: ТАВ, ТАЛГАА, БҮХ ХҮН